


# Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна

## Сайхан сэтгэлт Самари хүн



Зохиогч: Edward Hughes  
Зураглаач: M. Maillot; Lazarus

Орчуулсан: Damdin Horolsuren  
Найруулсан: Ruth Klassen; Sarah S.

Түүх 46/60

[www.M1914.org](http://www.M1914.org)

*Bible for Children, PO Box 3, Winnipeg, MB R3C 2G1 Canada*

Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах эрхтэй харин худалдахыг хориглоно.

Монгол хэл

Mongolian



"Бурхан Эзэнээ хайрла хөршөө хайрла" гэсэн байдаг гэж өнөөх хүн хариулав. Тэр "Гэвч хэн миний хөрш вэ?" хэмээн асуув.



3

Түүний асуултад хариу болгож Есүс Иерусалемаас Иерохо орохоор явсан нэгэн хүний тухай түүх ярив. Тэр хүн уруу дээрэмчид дайрчээ.



4

Дээрэмчин түүний бүх зүйлийг нь булаан авч хувцсыг нь хүртэл тайлан авчээ. Тэд түүнийг хүндээр шархдуулж түүний хагас үхсэн биеийг замын хажууд хаяжээ.



5

5

Азаар нэгэн тахилч хүн тэр замаар ирж явав. Тэр шархдсан хүнд туслах нь гарцаагүй.



6

6

Үгүй ээ! Тэр тахилч цустайгаа холилдсон тэр хүнийг хараад өөр замаар тойроод явчлав.



7

7

Удалгүй нэгэн хүн тэр замаар ирж байв. Тэр бол сүмд тахил өргөдөг Левит хүн байв. Тэр ирээд бэртсэн өнөөх хүнийг харсан ч туслалгүйгээр явчлав.



8

8

Эцэст нь тэр замаар Самари хүн ирж байв. Иудей хүмүүс Самари хүмүүсийг үзэн яддаг байжээ.




9

Есүсийн яриаг сонсож байсан хүмүүс Самари хүнийг ярих үед түүнийг баатар гэж төсөөлөө ч үгүй байв.



10

Гэвч тэр баатарлаг хүн байлаа. Самари хүн зогсон түүнд туслан түүнийг асрав.



11

Самари хүн өвдөглөн сууж түүний шархыг боож өгөв. Тэгээд өвчтэй хүнийг өөрийн илжгэндээ тэгнэлээ.



12

Замаар явсаар нэгэн дэн буудалд ирж Самари хүн өнөөх өвчтэй хүнийг шөнөжингөө асарчээ.



13

Өгөө болоход тэр буудлын эзэнд мөнгийг нь төлөөд өвчтэй хүнийг сайжиртал асарч байгаач хэмээн захижээ.



14

Энэ түүхийг ярьж дуусаад Есүс  
"Өвчтэй хүний хөрш нь хэн бэ?"  
гэж асуув.



15



Хуулийн багш  
"Түүний хөрш  
энэрлийг үзүүлсэн  
Самари хүн" гэв.

16

"Явж түүнтэй адил  
үйлд" хэмээн Есүс  
хэлэв. Хөрш бол  
тусламж хэрэгтэй  
хэн нэгэн юм.



17

Бид тэдгээр  
хүмүүст туслан  
хайраа харуулах  
хэрэгтэй. Үүнчлэх  
үйлдэхэд Бурхан  
баярладаг юм.



18

Сайхан сэтгэлт Самари хүн

Бурханы үг Библээс авсан түүх

Лук 10

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."  
Дуулал 119:130

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл юм.

Бурхан бидэнд маш их хайртай Тэрээр өөрийн хүү Есүсийг бидний гэмийн төлөөс болгон загалмайн үхэлд тушаасан. Есүс дахин амилж мөнхийн улсдаа буцсан! Одоо Бурхан бидний гэмийг уучилж чадна.

Хэрвээ та гэмээсээ эргэхийг хүсвэл, Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Бурхан минь ээ, Би Есүс миний төлөө үхээд дахин амилсан гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач тэгээд би шинэ амьдралаар амьдарч дараа нь тантай хамт мөнхөд амьдрах болно.

Таны хүүхэд шиг Таны төлөө амьдрахад туслаач.

Амен Иохан 3:16

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай!